

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2018 оны 3-р сарын 28-ны байдлаар


2018 оны 3-р сарын 28-ны байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 9.6 хувь, өмнөх 7 хоногтой харьцуулахад 0.7 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2018 оны 3-р сарын 28-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 19.8 хувь, үхрийн ястай махны үнэ 15.0 хувь, үхрийн цул махны үнэ 14.8 хувь, адууны ястай махны үнэ 6.5 хувь, ямааны махны үнэ 32.8 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 0.6 хувь, үхрийн ястай махны үнэ 1.3 хувь, үхрийн цул махны үнэ 1.1 хувь, ямааны ястай махны үнэ 6.6 хувь, адууны ястай махны үнэ 5.4 хувиар тус бүр өссөн байна.

2018 оны 3-р сарын 28-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 7120 төгрөг, үхрийн /ястай/ мах 8180 төгрөг, үхрийн цул мах 9720 төгрөг, адууны /ястай/ мах 5875 төгрөг, ямааны /ястай/ мах 5400 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).

Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ




Гурилын үнэ: 2018 оны 3-р сарын 28-ны байдлаар савласан дээд гурилын үнэ өмнөх сараас болон өмнөх 7 хоногтой харьцуулахад гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2018 оны 3-р сарын 28-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

Элсэн чихрийн үнэ өмнөх сартай харьцуулахад 0.1 хувиар өссөн бол өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна. (Зураг2).

Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2018 оны 3-р сарын 28-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 16.3 хувь, луувангийн үнэ 12.0 хувь, байцааны үнэ 8.3 хувь, хүрэн манжингийн үнэ 17.3 хувь, сонгины үнэ 5.8 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногийнхоос хүрэн манжингийн үнэ 11.7 хувь, сонгины үнэ 1.1 хувиар өссөн бол бусад ногооны үнэ өөрчлөлтгүй байна.

Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ: 2018 оны 3-р сарын 28-ны байдлаар сүүний үнийг өмнөх сарынхтай харьцуулахад задгай сүүний үнэ 1.0 хувь, савласан /1 литрийн/ сүүний үнэ 8.7 хувь, “элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 7.0 хувиар өссөн байна. Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

Ургамлын тосны үнэ өмнөх сараас болон өмнөх 7 хоногоос 1.0 хувиар өссөн бол цөцгийн тосны үнэ өмнөх сараас 2.2 хувь, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.